



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/10

Чингис хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2020 оны 156 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны №01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед шуурхай штабын ажиллах түр журам”-ыг нэгдүгээр, “Хот хоорондын хүнс тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Шуурхай штаб, Хот хоорондын хүнс тээвэрлэлтийг журмын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Авто тээврийн төв /Б.Ганбат/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/, Цагдаагийн Газар /Б.Батсайхан/ нарт нэгдсэн удирдлагаар хангаж мэдээ мэдээллийг нэгтгэн танилцуулж ажиллахыг Шуурхай штаб /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-т тус тус даалгасугай.

3. Онцгой комиссын шийдвэрийг эрчимжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штаб /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-т тус тус үүрэг болгосугай..

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010040

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед шуурхай штаб дахь салбар хоорондын байгууллагуудын үйл ажиллагааны харилцааг зохицуулахад оршино.

1.2. Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахалтай тэмцэх бодлогыг Эрүүл мэндийн газрын дарга удирдаж, өдөр тутмын зохицуулах үйл ажиллагааг шуурхай штабын дарга чиглүүлэн зохион байгуулна.

1.3. Шуурхай штаб нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын шийдвэр, албан даалгавар болон холбогдох норм дүрэм стандартыг мөрдлөгө болгож ажиллана.

Хоёр. Шуурхай штабын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг

2.1. Шуурхай штабын

ахлагч:

Онцгой комиссын гишүүн

Гишүүдэд:

Эрүүл мэндийн газар

Онцгой байдлын газрын алба хаагч

Мэргэжлийн хяналтын газар

Цагдаагийн газраас тус нэг алба хаагч байна.

2.2. Шуурхай штабын ахлагч, салбар хоорондын уялдааг ханган ажиллах үүрэг бүхий гишүүдийг Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга томилно.

2.3. Гишүүдийн ажиллах чиг үүрэг

2.3.1. Онцгой комиссын гишүүн

- 24 цагаар шуурхай штабд үүрэг гүйцэтгэхгүй бөгөөд тухайн өдрийн штабын бэлтгэл бэлэн байдал, үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавих.

- Шуурхай штабын бүрэлдэхүүнд ажиллаж буй гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, Шуурхай штабын дарга, менежерийг мэдээ мэдээллээр хангах.

- Шуурхай штаб, шалган нэвтрүүлэх цэгт ирсэн мэдээллийг өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомж, албан даалгавар, захирамж болон холбогдох албан бичгийн хүрээнд шийдвэрлэх.

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, томоохон худалдааны төв зэрэг газруудад Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Онцгой комиссын албан даалгавар, тэмдэглэл, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

2.3.2. Эрүүл мэндийн газрын алба хаагч нь:

- Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвөөс мэдээ мэдээллийг авч нэгтгэх

- Халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдолд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг хариуцаж ажиглалт, тусгаарлалтад байгаа иргэдийн эмнэл зүйн тандалтын мэдээллийг цуглуулж, мэдээллийн урсгалын дагуу хариу арга хэмжээг авах.

- 70562906, 7056290 дугаарын утсаар ирсэн гомдол мэдээллийг бүртгэн авч иргэдэд үнэн зөв мэдээллээр хангах.

- Хэнтий аймагт нэвтрэн ирсэн тээврийн хэрэгсэлд ариутгал халдваргүйтгэл хийлгэсэн талаар бүртгэлийг авч мэдээлэлд оруулах.

- Шуурхай штабын мэдээллийн дэвтрийн тэмдэглэл, бүртгэл хөтлөлтийг бүрэн хариуцах.

2.3.3. Онцгой байдлын газрын алба хаагч нь:

- Улсын Онцгой комисс, шуурхай штаб, аймаг орон нутгаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж холбогдох чиглэл мэдээллээр хангах.

- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Улсын Онцгой комисс, бүсийн төв, аймаг орон нутагт илтгэх хуудсаар танилцуулах.

- Шуурхай штабт үүрэг гүйцэтгэж байгаа байгууллагуудын уялдаа холбоог зохион байгуулж, аймаг, сумдын шуурхай штаб, шалган нэвтрүүлэх цэгт гарсан хүндрэлийг холбогдох албан тушаалтанд дамжуулж шийдвэрлэх арга хэмжээг авах.

2.3.4. Мэргэжлийн хяналтын газрын албан хаагч нь:

- Иргэдээс ирсэн гомдол мэдээллийг бүртгэн авч холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах.

- Аж ахуйн нэгж байгууллагын халдвар хамгааллын дэглэм, нийтээр даган мөрдөх журамд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах.

- Шалган нэвтрүүлэх цэгээр дамжин өнгөрч байгаа автомашин болон зорчигчдын бүртгэлийн судалгаанд хяналт тавих.

2.3.5. Цагдаагийн газрын алба хаагч нь:

- Хорио цээрийн дэглэм сахиулж хяналтын цэгээр нэвтрэн гарч буй иргэн, тээврийн хэрэгслийн мэдээллийг авч бүртгэл судалгааг хөтлөх.

- хорио цээрийн дэглэм зөрчсөнтэй холбоотой мэдээллийг түргэн шуурхай танилцуулах, хариу арга хэмжээ авах.

- Иргэдээс ирсэн гомдол мэдээллийг бүртгэн авч холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах.

Гурав. Шуурхай штабын албан тушаалтны үүрэг.

3.1. Үүсэн нөхцөл байдалтай холбоотой мэдээллээр онцгой комисс, холбогдох байгууллага, албан тушаалтныг хангана.

3.2. Шуурхай штабыг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.

3.3. Штабын дарга, менежерийг чиглүүлж бодлогын дэмжлэг үзүүлэх, хариу арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой мэдээллээр хангана.

3.4. Шуурхай штабын тусгай утсаар болон бичгээр ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэх талаар штабын даргад мэдээлж хариу арга хэмжээг шуурхай авч ажиллана.

3.5. Шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээс ирсэн мэдээллийг авч нэгтгэн Улсын онцгой комиссын шуурхай штаб, зүүн бүсийн төвийн шуурхай штабуудад хүргэх.

3.6. Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт орж гарах хөдөлгөөн хийж буй зөрчилтэй тээврийн хэрэгслийг шуурхай штабын даргад мэдэгдэж шийдвэр гаргуулах.

3.7. Нэгдсэн тайланг баталгаажуулж штабын даргад танилцуулна.

Дөрөв. Шуурхай штабын даргын үүрэг.

4.1. Шуурхай штабын дарга нь Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргыг мэдээ, мэдээллээр хангаж, шуурхай штабыг зохицуулах түвшний удирдлагаар хангаж ажиллана.

4.2. Шуурхай штабын даргын өгсөн үүргийг штабын гишүүд биелүүлнэ.

4.3. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулалтаар хангана.

Тав. Менежерийн үүрэг

5.1. Шуурхай штабын даргыг эрүүл мэндийн чиглэлийн мэдээ мэдээллээр хангах.

5.2. Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг төлөвлөх, мэргжил арга зүйгээр хангах.

5.3. Шуурхай штабын тайлан, иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, асуумж, бичиг баримтыг архивлан мэдээллийн сан үүсгэх.

5.4. Шуурхай штабын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

Зургаа. Бусад

6.1. Байгууллагууд хоорондоо үйл ажиллагаагаа уялдуулж хамтран ажиллана.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ХОТ ХООРОНДЫН ХҮНС ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, хот хоорондын ачаа тээвэрлэлтийг зохицуулах, тээвэрлэлтэд явж байгаа жолооч нарыг халдвар хамгаалалтын дэглэм сахиулах тэдний хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2 Энэхүү түр журмыг хот хоорондын хүнсний тээвэрлэлт хийх QR кодтой зөвшөөрөл авсан жолооч нар дагаж мөрдөнө.

Хоёр. Хот хоорондын тээврийн хэрэгсэлд QR код олгох

2.1 Хэрлэн сумын онцгой комиссын хүнсний эрүүл ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /www.teeverzuuch.mn/-системд нэвтрэн тээвэрлэлтийн эрхээр орж, хүнсний тээвэрт явах жолоочийн ачаа тээврийн захиалгыг оруулна.

2.2 Аймгийн авто тээврийн газар нь /www.teeverzuuch.mn/- системд нэвтрэн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын оруулсан захиалгыг баталгаажуулан системээс QR код авч тээвэрлэлт хийх жолоочид олгоно.

2.3 Улаанбаатар хотоос хүнс тээвэрлэж ирсэн жолооч гэрийн ажиглалтад 7 хоног байх хугацаанд, ээлжийн жолоочид QR код авч тээвэрлэлтэд явах эрх олгоно.

Гурав. Хот хоорондын ачаа тээвэрлэлтийг хянах

3.1 Хяналтын байгууллагын ажилтан гар утсандаа QR код уншигч суулгасан байна.

3.2 Хяналтын байгууллагын ажилтан QR кодыг шаардах бөгөөд уг кодыг уншуулж тээвэрлэлт болон маршрутын мэдээллийг авна.

3.3 Тээвэрлэлтийн QR кодны хугацаа нь дууссан тохиолдолд кодыг нь хураан авна.

3.4 Хүнсний тээвэрлэлтээс бусад тээвэрлэлт хийх, зорчигч тээвэрлэх, ачаа тээвэрлэлтийн үнийг үндэслэлгүй нэмэх зэрэг зөрчил гаргасан тохиолдолд QR кодыг хураан авч тээвэрлэлт хийх эрхийг нь хязгаарлана.

3.5 Улаанбаатар хот тээвэрлэлтэд явах, аймагт ирэх бүрдээ PCR лабораторийн шинжилгээнд хамрагдсан байхыг шаардаж шалган нэвтрүүлнэ.

3.6 Хүнс тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийг Чингис хаалгаар нэвтрэн орж ирэхэд халдваргүйжүүлэлт хийнэ.

3.7 Улаанбаатар хотоос хүнс тээвэрлэж ирсэн жолооч гэрийн ажиглалтад 7 хоног байсан, PCR болон түргэвчилсэн оношлуураар шинжилгээ өгсөн эсэхэд хяналт тавина.

3.8 Хүнс тээвэрлэж байгаа тээврийн жолооч нар хамгаалалтын хувцас, нүүрний хамгаалалт, бээлий, гар ариутгагч, амны хаалт зэрэг хувийн хамгаалах хэрэгслийг бүрдүүлж, эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу зөв зохистой хэрэглэж, устгаж байгаа эсэхэд хяналт хийнэ.

Дөрөв. Хот хоорондын тээвэрт явж буй жолооч нарын хүлээх үүрэг

4.1 Хүнс тээвэрлэлтэд гарч байгаа тээврийн хэрэгсэл, чингэлгийг тухай бүр Зооноз өвчин судлалын төвд ариутгуулсан байна.

4.2 Жолооч нар хүнс тээвэрлэх хугацаанд хамгаалалтын хувцас, нүүрний хамгаалалт, бээлий, гар ариутгагч, амны хаалт зэрэг хувийн хамгаалах хэрэгслийг бүрдүүлж, эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу зөв зохистой хэрэглэж, хангалттай нөөцийг бэлтгэн авч явна.

4.3 Жолооч байнга оршин сууж байгаа хаяг, ар гэрийн судалгаа, шаардлагатай тохиолдолд холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх.

4.4 Тээвэрлэлт хийх явцад жолооч ил задгай хог хаягдал хаяхгүй, хог хаягдлыг хогийн уутанд цуглуулан, зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаяж гарыг ариутгаж байх.

4.5 Жолооч тээврийн замд гарахдаа шаардлагатай хоол хүнс, хувийн эд зүйлсийг бэлтгэж, авч явна.

4.6 Хот суурин газрыг дайран өнгөрөхдөө хоолны газраар болон үйлчилгээний цэгүүдээр орохгүй, аль болох зогсохгүй, шаардлагатай тохиолдолд түр зогсолт хийвэл тээврийн хэрэгслээс буухгүй байх.

4.7 Постоор орох, гарах үед бүртгэл, хяналт хийлгэх, зэрэг хүнтэй харьцах бүрдээ амны хаалт зүүж, бээлий өмсөж, 2 метрээс багагүй зайнаас харьцах.

4.8 Тээвэрлэлтийн явцад тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулахгүй байх, бусад жолооч, ажилтан, иргэдтэй уулзахгүй байх.

4.9 Өөрт халуурах, ханиах зэрэг халдварын шинж тэмдэг илэрвэл тээвэр гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн удирдлага, эрүүл мэндийн ажилтанд шуурхай мэдэгдэж, хорио цээрийн дэглэмийг чанд сахих, мэдээ өгөх, холбоо барих утсаа байнга цэнэгтэй байлгах.

4.10 Техникийн болон бусад зайлшгүй шаардлагаар зам дагуух авто засвар, шатахуун түгээх газар бусад үйлчилгээний газруудаар үйлчлүүлэн төлбөр тооцоо хийх үед нэг удаагийн бээлий өмсөх.

4.11 Хүнс тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд зорчигч авч явахгүй байх.

4.12 Улаанбаатар хотоос хүнсний бараа тээвэрлэж ирээд Авто тээврийн газрын гадна зогсоолд зогсож, хүн хоорондын зай барьж, өглөөний 08:30 оройн 18:00 цагт авто тээврийн зохицуулагчид бүртгүүлнэ.

4.13 УБ хотоос нэг ААН-ийн барааг тээвэрлэж ирсэн бол шууд тухайн байгууллагын гадна буулгана. 2 ба түүнээс дээш хүлээн авагчтай, зарим жижиг оврын бараа тээвэрлэн ирсэн тохиолдолд Авто тээврийн газрын тогтоосон цэгт буулгаж, ариутгуулан эзэнд нь хүлээлгэн өгнө.

4.14 Иргэд ААН-н бараа болон ачааг ачих болон хүлээлгэн өгөхдөө халдвар халдвар хамгааллын хувцас өмсөж, дэглэм чанд баримтална.

4.15 Ачаа илгээх, хүлээн авах, тээвэрлэхэд Улсын онцгой комисс, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, зөвлөмж, дэглэмийг мөрдөж ажиллана.

4.16 Улаанбаатар хотоос хүнс тээвэрлэж ирсэн жолооч гэрийн ажиглалтад 7 хоног байх ба харьяа багтаа болон өрхийн эрүүл мэндийн төвд утсаар мэдэгдсэн байна.

4.17 Гэрийн ажиглалтад байгаа жолооч нь халдвар хамгааллын дэглэм сахиж, гэр бүлийн гишүүдээс аль болох тусдаа байж, өрхийн эрүүл мэндийн төвийн эмчийн хяналтад байна.

4.18 Жолооч Хэрлэн сумын онцгой комиссын байршил тогтоох программд бүртгүүлж, тусгаарлагдах хугацаанд гар утсаа нээлттэй, датаг асаалттай байлгаж биедээ байнга авч явна.

4.19 Гэрийн ажиглалтын хугацаа дуусмагц өрхийн эрүүл мэндийн төвийн эмчээс зөвшөөрөл авч түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд хамрагдаж, дараагийн тээвэрлэлт хийх эрхээ авна.

Тав. Түр журмыг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага

5.1 Энэхүү түр журмыг зөрчсөн хот хооронд хүнсний тээвэрлэлт хийж буй жолооч нарт Монгол Улсын Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Түр журмын хугацаа

6.1 Энэхүү түр журам нь батлагдсан өдрөөс Хэрлэн сумын хэмжээнд улсын болон аймаг сумын онцгой комиссоос гаргасан шийдвэр, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.